



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2012 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: Дизель станц нийлүүлэх
Тендер шалгаруулалтын дугаар: DL-2012/01

Монголбанк нь эрх бүхий тендерт оролцогчдоос ажлын хэрэгцээнд зориулан дизель станц нийлүүлэх битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Тендер нь дараах багцтай байна. Үүнд:

Багц 1: Дизель станц

Тендерийн бичиг баримтыг бичгээр хвсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 60,000 (жаран мянган) төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хвчинтэй байна. Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгож байгаа үнийн дүнгийн 2 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрнө.

Тендерийн баримт бичгийн үнийг Монголбанкны 4101000014 тоот дансанд тушаана.

Тендерийг 2012 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хвсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2012 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ. Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.

Сонирхсон этгээд тендерийн бичиг баримт болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

МОНГОЛБАНК

Бага тойруу 3, Улаанбаатар 15160, А байрны 1 давхар 2 тоот өрөө,

Утас: 11-327048, Факс: 976-11-311471